



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлүүн сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/65/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас:70422954 Цахим хаяг: Khuanganm@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг:jenisbekh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Назгүл Утас:99427301 Цахим хаяг: nazguld@audit.gov.mn</p> <p>Уужим Алтай Аудит ХХК-ны аудитор: Х.Айгерим Утас:94911004 Цахим хаяг: aykonkh1005@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3.Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт.....	17
4.3 Албан шаардлага	18
4.4 Зөвлөмж	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсонүгийнжагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын санал, дүгнэлт

 БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgiu@audit.gov.mn	ДЭЛҮҮН СУМЫН ХҮҮХДИЙН 2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ М.АЛТЫНАЙ ТАНАА
2022.08.16 № 58	
танай _____-ны № _____-т	
АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	
Зөрчилгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлүүн сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p>	
<p>Дэлүүн сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p>	
<p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.</p>	
Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага	
<p>Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.</p>	

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>12,933,308.12</u>	<u>30,212,161.40</u>
33	АВЛАГА	274,453.12	15,000,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	274,453.12	0.00
335	Бусад авлага	-	15,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	15,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	12,658,855.00	15,212,161.40
354	Хангамжийн материал	12,658,855.00	15,212,161.40
35420	Аж ахуйн материал	6,513,000.00	6,833,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,928,880.00	502,650.41
35460	Хүнсний материал	2,282,775.00	3,581,685.99
35470	Бусад хангамжийн материал	1,934,200.00	4,294,825.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>191,509,171.41</u>	<u>187,992,852.21</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	191,509,171.41	187,992,852.21
392	Биет хөрөнгө	185,517,171.37	182,088,852.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(3,173,071.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,557,400.00	6,117,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,045,479.96)	(2,412,959.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,089,960.00	13,475,060.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(468,999.96)	(2,301,867.71)
393	Биет бус хөрөнгө	5,992,000.04	5,904,000.08
39302	Хуримтлагдсан элэгдэл	(87,999.96)	(175,999.92)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>204,442,479.53</u>	<u>218,205,013.61</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>204,442,479.53</u>	<u>218,205,013.61</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	204,442,479.53	218,205,013.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,200,000.00	5,200,000.00
51101	Өмч: - төрийн	5,200,000.00	5,200,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	199,242,479.53	213,005,013.61
51210	Өмнөх үеийн үр дүн	199,242,479.53	199,242,479.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	570,723,191.29	420,629,315.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,440.00	2,043,015.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,440.00	2,043,015.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,440.00	2,043,015.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	33,440.00	2,043,015.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	570,689,751.29	418,586,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	560,662,751.29	409,043,300.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	177,104,251.29	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	383,558,500.00	409,043,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	205,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,027,000.00	9,338,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,027,000.00	9,338,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	392,920,865.99	406,866,780.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	392,920,865.99	406,866,780.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	385,730,253.99	393,163,716.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,650,700.00	314,264,653.12
210101	Үндсэн цалин	289,465,785.00	278,586,153.12
210104	Урамшуулал	18,184,915.00	24,823,700.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	10,854,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,911,244.61	44,021,200.00
210201	Тэтгэврийн даатгал	38,911,244.61	29,965,700.00
210202	Тэтгэмжийн даатгал		3,154,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,523,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	630,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	7,746,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,494,120.00	10,464,229.59
210301	Гэрэл, цахилгаан	787,000.00	537,000.00
210302	Түлш, халаалт	9,707,120.00	9,927,229.59
2104	Хангамж, бараа материалын зардал	2,674,740.00	2,905,690.01
210401	Бичиг хэрэг	691,800.00	437,650.00
210402	Тээвэр, шатахуун	-	832,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	409,400.00	459,000.00
210404	Ном, хэвлэл	75,300.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,498,240.00	1,076,540.01
2105	Нормативт зардал	23,758,367.50	12,563,125.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	209,300.00	89,300.00
210502	Хоол, хүнс	22,504,267.50	11,748,825.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,044,800.00	725,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	50,000.00

210604	Урсгал засвар	-	50,000.00
2107	Томилолт, зочны зардал	114,000.00	446,400.00
210702	Дотоод албан томилолт	114,000.00	446,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	393,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	143,250.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,127,081.88	8,055,169.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	524,602.00	1,593,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,602,479.88	6,461,419.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,190,612.00	13,703,064.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,190,612.00	13,703,064.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,190,612.00	13,703,064.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>177,802,325.30</u>	<u>13,762,534.08</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>177,802,325.30</u>	<u>13,762,534.08</u>
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	570,723,191.29	420,629,315.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,440.00	2,043,015.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,440.00	2,043,015.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,440.00	2,043,015.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	33,440.00	2,043,015.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	570,689,751.29	418,586,300.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн	5,200,000.00	199,242,479.53		204,442,479.53
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,200,000.00	199,242,479.53	0.00	204,442,479.53
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,200,000.00	199,242,479.53	0.00	204,442,479.53
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,200,000.00	199,242,479.53	0.00	204,442,479.53
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн		13,762,534.08		13,762,534.08
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,200,000.00	213,005,013.61	0.00	218,205,013.61

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>393,585,500.00</u>	<u>418,586,300.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	393,585,500.00	418,586,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	383,558,500.00	409,043,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	383,558,500.00	409,043,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,027,000.00	9,338,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,027,000.00	9,338,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>393,225,502.00</u>	<u>415,641,200.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	393,225,502.00	415,641,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	386,034,890.00	401,938,136.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	306,980,888.00	315,428,500.00
210101	Үндсэн цалин	279,057,960.00	278,311,700.00
210104	Урамшуулал	27,922,928.00	24,823,700.00
210105	Гэрээт ажлын хөлс		12,293,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,819,000.00	42,582,900.00
210201	Тэтгэврийн даатгал	28,020,800.00	29,965,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,949,600.00	3,154,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,359,600.00	2,523,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	589,900.00	630,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,899,100.00	6,308,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,027,000.00	9,288,000.00
210301	Гэрэл, цахилгаан	787,000.00	787,000.00
210302	Түлш, халаалт	9,240,000.00	8,501,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,577,300.00	2,748,500.00
210401	Бичиг хэрэг	627,800.00	446,400.00
210402	Тээвэр, шатахуун		832,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	409,400.00	459,000.00
210404	Ном, хэвлэл	75,300.00	100,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		205,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,464,800.00	705,200.00
2105	Нормативт зардал	24,785,500.00	13,862,436.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	209,300.00	89,300.00

210502	Хоол, хүнс	23,531,400.00	13,047,736.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,044,800.00	725,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	15,050,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		15,000,000.00
210604	Урсгал засвар		50,000.00
2107	Томилолт, зочны зардал	114,000.00	446,400.00
210702	Дотоод албан томилолт	114,000.00	446,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,731,202.00	417,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,731,202.00	167,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,114,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,114,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,190,612.00	13,703,064.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,190,612.00	13,703,064.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,190,612.00	13,703,064.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>359,998.00</u>	<u>2,945,100.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	360,000.00	2,945,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	360,000.00	2,945,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	360,000.00	2,945,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	360,000.00	2,945,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(360,000.00)</u>	<u>(2,945,100.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(2.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2.00	

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	418,381,300	404,678,236
21	УРСГАЛ ЗАРДАЛ	418,381,300	404,678,236
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	418,381,300	404,678,236
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	315,428,500	315,428,500
210101	Үндсэн цалин	278,311,700	278,311,700
210104	Урамшуулал	24,823,700	24,823,700
210105	Гэрээт ажлын хөлс	12,293,100	12,293,100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,582,900	42,582,900
210201	Тэтгэврийн даатгал	29,965,700	29,965,700
210202	Тэтгэмжийн даатгал	3,154,300	3,154,300
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,523,400	2,523,400
210204	Ажилгүйдлийн даатгал	630,900	630,900
210205	Эрүүл мэндийн даатгал	6,308,600	6,308,600
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,288,000	9,288,000
210301	Гэрэл, цахилгаан	787,000	787,000
210302	Түлш, халаалт	8,501,000	8,501,000
2104	Хангамж, бараа материалын зардал	4,928,600	4,928,600
210401	Бичиг хэрэг	446,400	446,400
210402	Тээвэр, шатахуун	832,500	832,500
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	459,000	459,000
210404	Ном, хэвлэл	100,400	100,400
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,090,300	3,090,300
2105	Нормативт зардал	27,565,500	13,862,436
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	89,300	89,300
210502	Хоол, хүнс	26,750,800	13,047,736
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	725,400	725,400
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,050,000	15,050,000
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000	15,000,000
210604	Урсгал засвар	50,000	50,000
2107	Томилолт, зочны зардал	446,400	446,400

210702	Дотоод албан томилолт	446,400	446,400
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	417,400	417,400
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	167,400	167,400
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000	250,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,674,000	2,674,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,674,000	2,674,000
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	418,381,300	404,678,236
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	409,043,300	395,340,236
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	409,043,300	395,340,236
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,338,000	9,338,000
132001	Орон нутгийн төсвөөс	9,338,000	9,338,000
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	33	36
620002	Гүйцэтгэх ажилтан	20	21
620003	Үйлчлэх ажилтан	12	11
620004	Гэрээт ажилтан		3
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	200	100
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	200	100
630001	Төрийн өмчит ЕБС	200	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	205,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	205,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	205,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	205,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		205,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	205,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205,000.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дэлүүн сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн Аудитын газрын “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор Х.Айгерим гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Назгүл, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлүүн сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/1 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго нь сургуулийн өмнөх насны хүүхэдэд цогц хүмүүжил сургалт явуулах, тэдний авьяас чадварыг нээн илрүүлж, насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр бие даасан байдлыг хангах боломжийг бүрдүүлэхэд оршино.

Тус цэцэрлэг нь цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийг цэцэрлэгийн түвшинд хэрэгжүүлэх, хүүхдийн нас хөгжлийн онцлогт нийцсэн сургалт үйл ажиллагаа явуулах, бага насны хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагаанд багш, эцэг эх асран хамгаалагчын оролцоог нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2021 онд Дэлүүн сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2019,2020 оны санхүүгийн үйл ажиллагааг хамруулж шалгасан байна.

Цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжтэй ба эрхлэгчийн тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналтыг хэрэгжүүлдэг байна. Тус цэцэрлэгийн дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар аудитад туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлүүн сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 392.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дэлүүн сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13.86 сая төгрөгөөр буюу 6.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	274.5	15000.0	14725.5
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	12658.9	15212.2	2553.3
Үндсэн хөрөнгө	193111.7	187992.9	-5118.8
Нийт хөрөнгө	204442.5	218205.0	13762.5
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	204442.5	218205.0	13762.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	204442.5	218205.0	13762.5

Мөнгөн хөрөнгө, урьдчилгаа, өр төлбөрийн данс оны эхэнд болон эцэст үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 15.0 сая төгрөг болж нэмэгдсэн нь аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/1075 дугаартай захирамжаар сургууль, цэцэрлэгүүдийн төсвийн хэмнэлтээс төсөвт хийсэн зохицуулалтаар “Багшийн хөгжлийн танхим” ажиллуулахад зориулж тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авахад гэрээний дагуу шилжүүлж авлага үүсгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12.6 сая төгрөг болж 15.2 сая төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материалын зардлын дүн 2.4 сая төгрөгөөр өссөн буюу 2 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээж авснаас шалтгаалжээ.

Төсвийн хөрөнгөөр 25.4 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 24.9 төгрөгийн бараа материалыг зарцуулж, тайлант онд бараа материал актлаагүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 188.0 сая төгрөг болж 5.1 сая төгрөгөөр буурсан нь 2.9 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, тайлан хугацаанд 6.4 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 13.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 13.8 сая төгрөг гарсантай холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 420.6 сая төгрөг болж өмнөх оноос 150.1 сая төгрөгөөр буюу 26.3 хувиар буурсан дүнтэй байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан нь хөрөнгийн санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал 406.9 сая төгрөг болж өмнөх оноос 13.9 сая төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлэг зэрэг зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Дэлүүн сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны анх батлагдсан төсөв 453.1 сая төгрөг, тодотгосон төсөв 418.4 сая төгрөг байна.

Тодотгосон төсөв нь анх батлагдсан төсвөөсөө 34.7 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Үүнд: Цалингийн зардлыг 3.0 сая, нормативт зардлыг 47.7 сая төгрөгөөр бууруулж, багаж техник, хэрэгслийн зардлыг 15 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

Ковид-19 өвчний улмаас 2021 онд сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаанд тогтоогдсон хязгаарлалтын улмаас тус цэцэрлэгийн хоолны зардал төлөвлөснөөс 50 хувиар бага гүйцэтгэлтэй гарсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэх 453.1 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Нийт зарлагын 443.8 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 9.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 9.3 сая, тусгай зориулалтын шилжүүлгээс 409.1 сая, нийт 418.4 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 404.7 сая төгрөгийг зарцуулж, 13.7 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 404.7 сая төгрөг буюу 96.7 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны байгууллагаас нийт 0.2 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал зардалд 0.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлүүн сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны тасралт буюу Ковид цар тахлын өвчний улмаас 2021 оны санхүүгийн тайлантай холбоотой 15 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хил, гаалийн хаалттай байдал болон бэлтгэн нийлүүлэгчийн асуудлаас шалтгаалан тайлант онд худалдан авалт хийж чадаагүй боловч санхүүгийн тайланд тусгасан асуудал гарсан. Аудитын явцад үүнийг цаг үеийн асуудалтай хамааруулан үзэж, авлагын үлдэгдэлд тусгасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Дэлүүн сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Дэлүүн сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь 2021 онд шилэн дансанд оруулбал зохих нийт 151 мэдээллийн 143 мэдээллийг хугацаандаа оруулсан, 2 мэдээллийн оруулах хугацаа болоогүй ба 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тус байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- ✓ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлогын 12 гүйлгээнээс 28.2 сая төгрөгийн дүн бүхий 2 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, 64.8 сая төгрөгийн 4 гүйлгээг 12 дугаар сарын мэдээнд мэдээлээгүй орхигдуулсан.
- ✓ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш нийт худалдан авалтын зарлагын 6.4 сая төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байна.
- ✓ Авлага үүсгэсэн талаарх 15.0 сая төгрөгийн 1 мэдээллийг оруулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн дүнгээр 114.4 сая төгрөгийн албан шаардлага өгсөн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар 0.2 сая төгрөгийн шинээр үүсгэсэн авлагыг үүсгэж, төсөвт төвлөрүүлээгүй зөрчилд албан шаардлага, тооцооны дансаар дамжуулаагүй, бараа материалын тайланд орлого авалгүй шууд зардлаар бүтгэж, тайлагнасан 2.6 сая төгрөгийн зөрчил болон байгууллагын санхүүгийн үйл ажиллагаандаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг батлуулж, мөрдөөгүй байсан зөрчлүүдэд 2 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн байна.

Дэлүүн сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/10 дугаартай албан бичгээр зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг ирүүлсэн байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын мөрөөр хийсэн ажлын тайланг шилэн дансанд байршуулаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар Дэлүүн сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн ажил, гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл, зардлын дансны бичилт, няравын бараа материалын тайлан болон зарцуулалтад тавьсан хяналт, хөрөнгийн тооллого, тооцоо түүний үнэн бодит байдлыг шалгах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 471.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 347.3 сая төгрөгийн алдааг залруулж, 1.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 118.2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, 4.9 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх оны үлдэгдлийг буруу тайлагнасан, төсвийн гүйцэтгэлийн тайланд төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг 0.2 сая төгрөгөөр илүү тайлагнасан нийт 347.3 сая төгрөгийн алдааг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Цэцэрлэгийн эрхлэгч М.Алтынайд 0.7 сая, нягтлан бодогч А.Наригүлд 0.1 сая төгрөгийн цалин, урамшууллыг илүү олгосон, нягтлан бодогчийг жирэмсний амралттай байх хугацаанд түр ажилласан Ж.Лидад төрийн алба хаасны нэмэгдэлд 0.2 сая төгрөгийг

холбогдох эрхийн актгүй илүү олгосон, туслах багш Ж.Айжанд цалингийн зөрүү нэрээр гарт олгох дүнд үндэслэлгүй 0,3 сая төгрөгийг нэмж илүү олгосон зэрэг нийт 1.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон цалин, нэмэгдэл, урамшуулал болох 1.4 сая төгрөгийг хавсралтад заасан нэр бүхий хүмүүсээр төсөвт нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. Дэлүүн сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь тайлант онд гүйцэтгэлээр 404.7 сая төгрөгийг зарцуулсан ба 379.5 сая төгрөг нь байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардал бөгөөд үүнээс хоолны зардлыг 13.7 сая төгрөгөөр хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийнг шалгахад тэвчиж болох 38.8 сая төгрөгийн зардлыг 10 хувь буюу 3.8 сая төгрөгийн хэмнэлтийг гаргаж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 10.1.11-д заасныг үндэслэн гаргасан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тэвчиж болох зардлаас хэмнэж зарцуулаагүй 3.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлогын 12 гүйлгээнээс 28.2 сая төгрөгийн дүн бүхий 2 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, 64.8 сая төгрөгийн 4 гүйлгээг 12 дугаар сарын мэдээнд мэдээлээгүй орхигдуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш нийт худалдан авалтын зарлагын 6.4 сая төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, авлага үүсгэсэн талаарх 15.0 сая төгрөгийн мэдээллийг оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.3-д “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд хуулийн хүрээнд байршуулах мэдээллүүдээ хугацаандаа байршуулаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тэвэр, шатахуун, шуудан холбоо интернетийн төлбөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, нормын хувцас, зөөлөн эдлэл, бага үнэтэй түргэн элэгдэх зардлын нийт 2.9 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 1.7 сая төгрөгийн ажил гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, няравын бараа материалын тайлангийн орлого, зарлагын анхан шатны баримтууд дутуу, бараа

материалын үлдэгдлийг санхүүгийн тайлангийн үлдэгдлээс 0.3 сая төгрөгөөр зөрүүтэй гаргасан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 14.4, 14.4.5, 20.2, 20.2.5, 20.2.6 дахь заалтуудыг мөрдөж худалдан авсан бараа материалыг орлого авч тооцоо хийх, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах, санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж ажиллах, Сангийн сайдын 2010 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/ Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дэлүүн сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг	8	471.8	2	347.3	1	1.4	2	118.2	3	4.9